



**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

**Зөвлөх үйлчилгээний журам
батлах тухай**

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт 26.5 дахь заалт, “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт, Боловсролын Магадлан Итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын сургалтын байгууллагад өгөх “Зөвлөх үйлчилгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын албаны Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн бүрд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, чанарын баталгаажуулалт хариуцсан шинжээч (Б.Соёлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.АРИУНБОЛД

Боловсролын Магадлан Итгэмжлэх
Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны
захирлын 2023 оны 02 дугаар сарын
17-ний өдрийн 1736 тоот тушаалын
хавсралт



Зөвлөх үйлчилгээний журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл нь боловсролын сургалтын байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.
- 1.2. Зөвлөх үйлчилгээ нь боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой захиалгат сургалт, судалгаа, шинжилгээ хийх үйлчилгээ юм.
- 1.3. Боловсролын сургалтын байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.
- 1.4. Зөвлөх үйлчилгээг шинжээч, мэргэжилтнүүд багаар болон ганцаарчлан өгч болно.
- 1.5. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх шинжээч, мэргэжилтнийг Ажлын албаны захирал томилно.

Хоёр. Зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим, шинжээч, мэргэжилтэнд тавих шаардлага

- 2.1. Боловсролын сургалтын байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтална.
 - 2.1.1. Олон нийтэд ил тод, нээлттэй үйлчилж, оролцогч талуудын хэрэгцээг тэгш хангах;
 - 2.1.2. Хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлж, мэргэжлийн зөвлөгөө өгөх;
 - 2.1.3. Ашиг сонирхлоос ангид байх;
 - 2.1.4. Бусдын нөлөөнд автахаас зайлсхийж, захиалагчийн нууцыг чанд хадгалах;
- 2.2. Боловсролын сургалтын байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэх шинжээч, мэргэжилтэнд дараах шаардлагыг тавина.
 - 2.2.1. Боловсролын талаар баримтлах бодлого, хууль, дүрэм, журам, болон боловсролын салбарын сүүлийн үеийн сайн туршлага, чиг хандлагын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх;
 - 2.2.2. Тухайн сургуулийн асуудлыг тодорхойлж, оношлох, үнэлэх, зөвлөгөө өгөх;
 - 2.2.3. Хэрэгцээг урьдчилан таамаглаж, боломжит шийдлийг санал болгох;
 - 2.2.4. Эелдэг, хүндэтгэлтэй байж, асуултад тодорхой бөгөөд товч хариулт өгөх;

Гурав. Зөвлөх үйлчилгээний чиглэл

- 3.1. Зөвлөх үйлчилгээг дараах чиглэлээр зохион байгуулна.
 - 3.1.1. Боловсролын сургалтын байгууллага:

- 3.1.1.1. Сургалтын байгууллагын эрх зүйн орчин
- 3.1.1.2. Байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага /Тус сэдвийн хүрээнд 3 багц сургалт багтана. 3 шалгуур 1 багц сургалт болох ба захиалагч шалгууруудаа өөрсдөө сонгоно./
- 3.1.1.3. Байгууллагын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан бичих арга зүй
- 3.1.1.4. Өөрийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичгийн бүрдүүлэлт
- 3.1.1.5. Байгууллагын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээ хийх арга зүй
- 3.1.1.6. Боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо
- 3.1.1.7. Сургалтын байгууллагын засаглал, манлайлал
- 3.1.1.8. Сургалтын байгууллагын санхүүжилт
- 3.1.1.9. Олон улсын магадлан итгэмжлэлийн чиг хандлага
- 3.1.1.10. Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагын шинжээчид тавих шаардлага
- 3.1.2. Боловсролын сургалтын хөтөлбөр:
 - 3.1.2.1. Сургалтын хөтөлбөрийн эрх зүйн орчин
 - 3.1.2.2. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага /доктор, магистр, бакалавр/
 - 3.1.2.3. Урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага /доктор, магистр, бакалавр/
 - 3.1.2.4. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан бичих арга зүй
 - 3.1.2.5. Өөрийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичгийн бүрдүүлэлт
 - 3.1.2.6. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын тогтолцоо
 - 3.1.2.7. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээ хийх арга зүй
 - 3.1.2.8. Сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй
 - 3.1.2.9. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд үнэлгээ хийх арга зүй
 - 3.1.2.10. Хичээлийн суралцахуйн үр дүнд үнэлгээ хийх арга зүй

Дөрөв. Бусад

- 4.1. Сургалтын байгууллага нь хүсэлт гаргасан тохиолдолд зөвлөх үйлчилгээг тусгайлан зохион байгуулна.
- 4.2. Зөвлөх үйлчилгээ авах байгууллага нь хүсэлтийн маягтыг бөглөж, баталгаажуулж, холбогдох материалыг хавсаргаж ирүүлнэ.
- 4.3. Зөвлөх үйлчилгээний төлбөрийг БМИҮЗ-ийн “Төлбөртэй үйлчилгээний үнийн тариф тогтоох тухай” тушаалын хавсралтад зааснаар тогтооно.
- 4.4. Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн шинжээч, мэргэжилтнүүд Ажлын албанд тайлан ирүүлнэ.
- 4.5. Ажлын албаны чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан ажилтан журмын хэрэгжилтийг хянаж, дүн шинжилгээ хийнэ.